

## ДААТГАЛЫН МЭДЭЭ

2011 оны 3 дугаар сар

### 1. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ:

2011 оны 3 дугаар сарын байдлаар даатгалын салбарт үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон тусгай зөвшөөрөлд орсон өөрчлөлтүүд дараах байдалтай байна:

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчид, өөрчлөлт	/тоогоор/			
		2011-II	Нэмэгдсэн	Хасагдсан	2011-III
1	Даатгалын компани	17			17
2	Даатгалын компанийн салбар	139			139
3	Даатгалын төлөөлөгч	1662		70 <sup>1</sup>	1592
4	Даатгалын зуучлагч	9			9
5	Даатгалын хохирол үнэлэгч	7			7
6	Актуарч	12			12
7	Бусад				

Тайлант үед даатгалын компани, тэдгээрийн салбар, даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгч, актуарчийн тоонд өөрчлөлт ороогүй байна.

<sup>1</sup>Хорооны даргын 2011 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 33 дугаар тушаалаар “Миг даатгал” ХХК-ийн 62 даатгалын төлөөлөгч, “Тэнгэр даатгал” ХХК-ийн 1 даатгалын төлөөлөгч, нийт 63 даатгалын төлөөлөгчийн, 2011 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн 48 дугаар тушаалаар “Улаанбаатар хотын даатгал” ХХК-ийн 3 даатгалын төлөөлөгчийн, Хорооны 2011 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 78 дугаар тушаалаар “Улаанбаатар хотын даатгал” ХХК-ийн 4 даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тус тус хүчингүй болгосон.

### 2. САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ:

Даатгалын байгууллагуудын 2011 оны 3 дугаар сарын даатгалын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийг 2010 оны 3 дугаар сарынхтай харьцуулбал:


#### Ердийн даатгалын компаниудын хувьд :

№	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2010-III	2011-III
1	Даатгалын нийт хураамж	2,584,022,865.0	4,063,199,298.0
2	Олгосон нийт нөхөн төлбөр	899,945,542.1	853,292,426.3
3	Давхар даатгалд төлсөн хураамж	240,750,111.0	850,356,640.1
4	Байгуулсан даатгалын гэрээний тоо /ширхэг/	7,585	15,045

5	Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	6,268,000,000.0	108,926,701,861.0
6	Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	227,184,000.0	67,729,000.0

2011 оны 3 дугаар сард даатгалын компаниудын төвлөрүүлсэн даатгалын нийт хураамжийн орлого нь өмнөх оны мөн үеийнхээс 1,479.2 сая төгрөгөөр, урд сарынхаас 1,755.6 сая төгрөгөөр тус тус өсч, олгосон даатгалын нөхөн төлбөр өмнөх оны мөн үеийнхээс 46.6 сая төгрөгөөр буурч, урд сарынхаас 286.7 сая төгрөгөөр өссөн, давхар даатгалд төлсөн хураамж өмнөх оны мөн үеийнхээс 609.6 сая төгрөгөөр, урд сарынхаас 340.1 сая төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Даатгалын компаниудын даатгалын хураамжийн орлого, нөхөн төлбөр, давхар даатгалд төлсөн хураамж, сая төгрөгөөр



Урт хугацааны даатгалын компанийн хувьд :

№	Үзүүлэлт	/төгрөгөөр/		
		2010-III	2011-II	2011-III
1	Даатгалын нийт хураамж	2,957,643.0	18,108,187.6	13,627,757.0
2	Олгосон нийт нөхөн төлбөр	765,000.0	4,740,740.0	10,461,378.0
3	Давхар даатгалд төлсөн хураамж	27,440,000.0		
4	Байгуулсан даатгалын гэрээний тоо	6	8	8
	Үүнээс: -Хувь хүний хугацаат даатгалд	3	2	2
	-Байгууллагын хугацаат даатгалд	3	2	3
	-Өндөр хамгаалалттай ЭМД-д			
	-Эмнэлгийн мөнгөний даатгалд			
	-Сургалтын төлбөрийн хуримтлалын даатгалд		1	1
	-Тэтгэврийн даатгалд			1
	-Орон сууцны даатгалд		1	

	-Хуримтлалын даатгалд		2	
	-Зээлдэгчийн амь насны даатгалд			1
5	Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	15,000,000.0	20,000,000.0	50,000,000.0
6	Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	400,000.0	320,000.0	1,750,000.0

“Нэйшнл лайф даатгал” ХХК-ийн 2011 оны 3 дугаар сарын даатгалын хураамжийн орлого болон нөхөн төлбөрийг 2010 оны мөн үеийнхтэй харьцуулбал даатгалын хураамжийн орлого 10.7 сая төгрөгөөр, даатгалын нөхөн төлбөр 9.7 сая төгрөгөөр тус тус өсч, өмнөх сарынхтай харьцуулахад даатгалын хураамжийн хэмжээ 4.5 сая төгрөгөөр буурч, даатгалын нөхөн төлбөр 5.7 сая төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

**Даатгалын зуучлагч компаниудын хувьд :**

№	Үзүүлэлт	/төгрөгөөр/		
		2011-I	2011-II	2011-III
1	Даатгуулагчаас шууд орж ирсэн даатгалын хураамж	17,536,876.2	12,278,487.7	67,806,527.4
2	Даатгалын зуучлагчийн орлого	13,180,745.4	12,488,198.0	26,375,510.9
3	Зуучилсан даатгалын гэрээний тоо	32	35	44
4	Зуучилсан даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	16,230,000,000.0	2,500,000,000.0	6,261,150,000.0

2011 оны 3 дугаар сарын байдлаар даатгалын зуучлагч компаниуд 44 даатгалын гэрээг даатгагчдад зуучлан 26.4 сая төгрөгийн зуучлалын орлого олсон байна.

**Даатгалын хохирол үнэлэгч компаниудын хувьд :**

№	Үзүүлэлт	/төгрөгөөр/		
		2011-I	2011-II	2011-III
1	Даатгалын хохирол үнэлсэний орлого	4,252,185.2	2,300,414.6	2,999,772.7
2	Үнэлсэн даатгалын хохирлын тоо	304	230	225
3	Үнэлсэн даатгалын хохирлоос хамгийн өндөр хохирлын дүн	28,870,000.0	24,074,000.0	33,160,000.0

2011 оны 3 дугаар сарын байдлаар даатгалын хохирол үнэлэгч компаниуд 225 даатгалын хохирлыг үнэлж, 3.0 сая төгрөгийн даатгалын хохирол үнэлсний орлоготой ажиллажээ.